

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2018 оны  
X сарын 17-ны өдрийн ажиглалт


Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 33 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2018 оны X сарын 3-р долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 25 нэрийн барааны үнэ **тогтвортой**, 2 нэрийн барааны үнэ **буурсан**, 6 нэрийн барааны үнэ **өссөн** байна. Үүнд :

- |  |   |   |
|--|---|---|
| <p>≈ Үнэ тогтвортой</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Алтан Тариа" задгай гурил дээд</li> <li>• "Алтан Тариа" задгай гурил I</li> <li>• "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд</li> <li>• "Алтан Тариа" савласан гурил дээд</li> <li>• "Алтан Тариа" савласан гурил I</li> <li>• "Алтан Тариа" савласан гурил II</li> <li>• "Алейка" гурил дээд</li> <li>• "Сүү" ХК савласан 0.5 л сүү</li> <li>• Сүү, задгай</li> <li>• Тараг, Цөцгийтэй</li> <li>• Талх, "Атар"</li> <li>• Талх, "Зууван чех"</li> <li>• Талх, "хөх тарианы хар"</li> <li>• Цагаан будаа</li> <li>• Шар будаа</li> <li>• Цөцгийн тос, Сүү ХК</li> <li>• Ургамлын тос, "Янта"</li> <li>• Ногоон цай, "Сtimo"</li> <li>• Элсэн чихэр</li> <li>• Үхрийн мах, цул</li> <li>• Төмс, монгол</li> <li>• Хүрэн манжин, монгол</li> <li>• Сонгино, хятад, бөөрөнхий</li> <li>• Алим, фүжи</li> <li>• Өндөг, ОХУ</li> </ul> | <p>⇩ Үнэ буурсан</p> <ul style="list-style-type: none"> <li>• Лууван, монгол</li> <li>• Байцай, монгол</li> </ul> | <p>⇧ Үнэ өссөн</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү</li> <li>• Хонины мах, ястай</li> <li>• Хонины мах, цул</li> <li>• Үхрийн мах, ястай</li> <li>• Адууны мах, ястай</li> <li>• Ямааны мах, ястай</li> </ul> |
|--|---|---|

### Махны дундаж үнэ

2018 оны X сарын 3-р долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 6370 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 7810 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 120 төгрөгөөр (1.6%) өссөн бол, харин үхрийн цул махны үнэ тогтвортой байлаа. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 6800 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 8500 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг



Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг


Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	7 335	8 025	7 895	8 330	8 380	8 275	8 225	7 710	7 825	7 245	7 115	7 280
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7810*		

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	6 480	7 095	7 060	7 420	7 490	7 470	7 415	6 710	6 540	6 215	6 085	6 245
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6370*		

\* 3-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 160 төгрөгөөр (2.6%), хонины цул махны үнэ 200 төгрөгөөр (3.0%) тус тус өссөн байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 5500 төгрөгөөр, харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 7500 төгрөгөөр худалдаалж байна.


### Гурилын үнэ

2018 оны X сарын 3-р долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1250-1500 төгрөг, 1-р зэргийнх 950-1200 төгрөг, 2-р зэргийнх 800-1000 төгрөг байна.


Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1250-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.



Зураг 3. Дээд зэргийн гурилын үнэ, 1 кг



Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг



“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1100-1210 төгрөгийн үнэтэй байна. “Бөмбөгөр”, “Оргил”, “Хүчит Шонхор”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1100 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетэд хамгийн өндөр үнээр буюу 1210 төгрөгөөр худалдаалж байна.

**Хүнсний ногооны үнэ**

2018 оны X сарын 3-р долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол лууван 2.3 хувиар буурч 1075 төгрөгөөр, байцаа 3.0 хувиар буурч 1130 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



**Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:**

- Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2018.X.17
- Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны VIII, IX, X сар
- Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2012-2018 оны X сарын 17
- Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2018.X.17
- Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны VIII, IX, X сарын ажиглалтаар
- Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2018 он
- Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2018.X.17